



**Монголын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын
үйл ажиллагааны тайлан**

2013 оны 6 дугаар сараас- 2014 оны 6 дугаар сар

**Монголын ОУИТБС-ын Үндэсний зөвлөл, Ажлын хэсэг
Ажлын алба**

АГУУЛГА

Нэг. 2013 оны сүүлийн хагас, 2014 оны эхний хагаст хэрэгжүүлсэн бодлого, үйл ажиллагаа, үр дүнгийн тухай;

Хоёр. ОУИТБС-ын шаардлага бүрийг хангасан байдал, явц;

Гурав. Баталгаажуулалтын зөвлөмжийн дагуу Үндэсний зөвлөл, Ажлын хэсгээс хэрэгжүүлсэн арга хэмжээний тойм;

Дөрөв. Ажлын төлөвлөгөөний биелэлтийн байдал, биелсэн зорилтуудын ач холбогдол;

Тав. Цаашид хэрэгжүүлэх ажлын томъёолол, оролцогч талуудын оролцоог нэмэгдүүлэх тухай;

Зургаа. Тайланг боловсруулсан, баталсан огноо;

Нэг. 2013 оны сүүлийн хагас, 2014 оны эхний хагаст хэрэгжүүлсэн бодлого, үйл ажиллагаа, үр дүнгийн тухай;

1.1. Үндэсний зөвлөл, Ажлын хэсгийн хуралдаануудын тойм

Үндэсний зөвлөл

Үндэсний зөвлөлийн хуралдаан 2013 оны сүүлийн хагас 1 удаа буюу 12 дүгээр сарын 23-ны өдөр хуралдаж, Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуяг оролцож, дэлгэрэнгүй үг хэлэв¹.

Ерөнхий сайд Н. Алтанхуяг Үндэсний зөвлөлийг сайн ажиллуулах, оролцогч тал бүр ил тод байдлын төлөө идэвхтэй хамтран ажиллах, тайлан гаргаагүй компаниудад хариуцлага тооцох талаар санаачлагатай ажиллахыг үүрэг болгосон байна.

Хуралдааны шийдвэрүүдийг сийрүүлэв. Үүнд:

1. Британийн Муур Стефенс, Монголын Далайван аудит компаниудын боловсруулсан Монгол Улсын ОУИТБС-ын 2012 оны нэгтгэл тайланг дэмжиж батлав. Энэхүү тайланг Монгол Улсын ОУИТБС-ын ажлын албаны вебсайт болон Сангийн яам, Уул уурхайн яам, Монголын уул уурхайн ассоциаци, Нээлттэй нийгэм форумын вебсайтад тус тус тавих, тайлангийн хураангуй хувилбарыг нийтэд ил тод болгох нь зүйтэй гэж үзэв. Монгол Улсын ОУИТБС-ын 2012 оны нэгтгэл тайлан, 2013 он ажлын төлөвлөгөөний биелэлт, 2014 оны төлөвлөгөөг ОУИТБС-ын олон улсын удирдах хороонд 2013 оны 12 дугаар сарын 31-ний дотор илгээхийг Ажлын албанд даалгав. Монгол Улсын ОУИТБС-ын 2012 оны нэгтгэл тайлангийн талаар ОУИТБС-ын Ажлын албатай хамтран нийтэд мэдээлж ажиллахыг Засгийн газрын хэвлэл мэдээллийн албанд даалгав. Хэвлэлийн бага хурлыг 2014 оны 2 дугаар сард зохион байгуулав.
2. Монгол Улсын ОУИТБС-ын 2012 оны нэгтгэл тайлангаар зөрүүтэй гэж гарсан компани, төрийн байгууллагууд зөрүүний тайлбараа 2014 он 1 дүгээр сарын 31-ний дотор нийтэд мэдээлэх нь зүйтэй гэж үзэв. Ажлын албанаас зөрүү бүхий 43 байгууллагад албан бичиг хүргүүлсэн бөгөөд тэдгээрийн 20 нь хариу ирүүлсэн байна. Энэ талаархи дүгнэлтийн Ажлын хэсгийн хуралдаанд танилцуулна.
3. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын хуулийг батлахаас өмнө 3 тал ил тод байдлын тайлангийн хамрах хүрээг 2014 оны 1 дүгээр сарын 31-ний дотор нягталж, шаардлагатай шийдвэрийг гаргах нь зүйтэй гэж үзэв. 2013 оны нэгтгэл тайланд хамрагдах компаниудын тоог гаргах явцад хамрах хүрээийн товч судалгааг гаргасан болно.
4. Монгол Улсын ОУИТБС-ын Үндэсний зөвлөлийн энэ хуралдааны ирцийг Ерөнхий сайдад танилцуулахыг Ажлын хэсэгт даалгав.
5. Монгол Улсын ОУИТБС-ын 2012 оны нэгтгэл тайланд сум, орон нутгийн түвшиний төлбөр, орлогыг ойлгомжтой байдлаар оруулахыг консерциумд зөвлөмж болгов. Консерциум холбогдох өөрчлөлтийг хийсэн байна.
6. Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс 2012 онд хүлээн авч, төвлөрүүлсэн нөхөн сэргээлтийн урьдчилгааны тухай танилцуулгыг зөвлөлд гаргаж өгөхийг Байгаль орчин ногоон хөгжлийн яаманд даалгав. Энэ ажлыг 2014 оны 9 дүгээр сард зохион байгуулна.
7. Монголын ОУИТБС-ын 2013 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг хангалттай гэж үзэв.
8. ОУИТБ-ын хуулийн төслийг Улсын Их хуралд 2014 оны нэгдүгээр улиралд багтаан өргөн барьж батлуулахыг Уул уурхайн яаманд даалгав. Хуулийн үзэл баримтлалыг Хууль зүйн

¹ Ерөнхий сайдын хэлсэн үгийг хавсаргав.

яамнаас батласан бөгөөд яамдуудаас санал авч Засгийн газрын хуралдаанд танилцуулахад бэлэн болоод байна.

9. ОУИТБС-ын цахим тайлагналыг 2014 онд хэрэгжүүлж, 2014 оны хоёрдугаар улиралд багтаан туршилтын дүнг танилцуулахыг Ажлын хэсэгт даалгав. Энэ ажлын явц сайн байгаа бөгөөд ирэх 8 дугаар сард зохих туршилтыг зохион байгуулна.
10. ОУИТБС-ын мэдээллийн төвийг сонгон авсан аймгуудад байгуулж, дүнг 2014 оны 3 дугаар улиралд багтаан танилцуулахыг Ажлын албанд даалгав. Одоогоор хөрөнгө эх үүсвэргүй учраас саатаад байна.
11. Монголын ОУИТБС-ын 2013 оны төлөвлөгөөний биелэлтийг олон нийтэд хүргэх, хэвлэлийн бага хурлыг 2014 оны 1 дүгээр сарын 15-ны дотор зохион байгуулахыг Ажлын албанд даалгав. Хэвлэлийн бага хурлыг 2014 оны 2 дугаар сард зохион байгуулсан байна.
12. Монголын ОУИТБС-ын 2014 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг Үндэсний зөвлөлийн гишүүдийн гаргасан саналыг тусган батлав². Ажлын төлөвлөгөө хэрэгжиж байна.
13. Төлөвлөгөөний биелэлтэд улирал бүр хяналт тавьж ажиллахыг Ажлын хэсэгт даалгав.
14. ОУИТБС-ыг орон нутагт хэрэгжүүлэх бүтэц, зохион байгуулалт, дэд зөвлөлийн ажиллах журмыг Үндэсний зөвлөлийн гишүүдийн гаргасан саналыг үндэслэж, холбогдох засварыг оруулан, зөвлөмж болгон гаргахаар батлав. Бүх аймгуудад зөвлөмжүүдийг хүргүүлж, 2014 оны 4 дүгээр сард зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулж, аймгууд 2014-2015 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөгөө боловсруулахаар болсон байна.
15. Дэд зөвлөлийн ажиллах журмын тухай зөвлөмжийг аймаг, нийслэл, сум дүүрэгт 2014 оны 1 дүгээр сарын 15-ны дотор хүргүүлж, холбогдох зааварчилгаа өгөхийг Ажлын албанд даалгав. Энэ ажлыг Ажлын албанаас зохион байгуулсан.

Ажлын хэсэг

ОУИТБС-ыг хэрэгжүүлэх үүрэг бүхий олон талт Ажлын хэсэг 2013 оны 10 дугаар сард 1 удаа, 12 дугаар сард 2 удаа, 2014 оны 3 дугаар сард 1 удаа, бүгд 4 удаа хуралдав. Хуралдаан бүрийн шийдвэрийг сийрүүлэв. Үүнд:

2013 оны 10 дугаар сарын 23-ны өдөр

Энэ хурлаар дараахь асуудлуудыг хэлэлцэх байсан боловч ирц бүрдээгүйн улмаас зөвхөн 1 дүгээр асуудлыг сонсож, танилцсан байна. Ажлын хэсгийн гишүүд санал бодлоо хэлсэн болно. Аудиторууд асуудлыг анхаарч, тайланг боловсруулахдаа тооцож үзэхээр болсон байна.

Хэлэлцэх байсан асуудлууд:

1. Монгол Улсын ОУИТБС-ын 2012 оны нэгтгэл тайлангийн явц, эхний тайлан- Их Британий Стефенс Мооре компани, Монгол Улсын Далайван аудит ХХК-ийн консерцумын төлөөлөл Б. Жигдэн, Радихууле нар танилцуулав.
2. Монголын ОУИТБС-ын 2013 оны ажлын төлөвлөгөөний биелэлтийн явц
3. Монголын ОУИТБС-ын 2014 оны ажлын төлөвлөгөөний төсөл
4. Аймгийн ОУИТБС-ын Дэд зөвлөлийн үйл ажиллагааны үлгэрчилсэн дүрмийн төсөл, төв байгуулах санал
5. Ажлын хэсгийн гишүүдэд өгөх сургалтын хөтөлбөрийг танилцуулж санал авах

2013 оны 12 дугаар сарын 3-ны өдөр

Хэлэлцсэн асуудлууд ба шийдвэрүүдийг сийрүүлэв. Үүнд:

² Монгол Улсын ОУИТБС-ын 2014 оны ажлын төлөвлөгөөг хавсаргав.

1. Монгол Улсын ОУИТБС-ын 2012 оны урьдчилсан нэгтгэл тайланг хэлэлцээд ажлын хэсгийн гишүүдээс хуралдаан дээр гаргасан саналыг судалж тусган, одоо хүлээгдэж байгаа тулгалтын тооцоогоо нэмж нэгтгэн, тоо баримт, үг хэллэг, найруулга зүйн алдаагсайтар хянаж, гэрээнд заасан ажлын даалгаврыг бүрэн гүйцэтгэж Монгол Улсын ОУИТБС-ын 2012 оны нэгтгэлийн эцсийн тайланг бэлтгэн Үндэсний зөвлөлийн хуралдаанд оруулж хэлэлцүүлэхээр тогтов.
2. Монгол Улсын ОУИТБС-ын 2012 оны нэгтгэл тайланг Үндэсний зөвлөлийн хуралдаанаас өмнө бүрэн эцэслэх ажлыг Ажлын албатай тохиролцож, гэрээний үнийн дүнгийн 80 хувийн төлбөрийг аудитын консорциумд олгохыг Ажлын албанд зөвшөөрөв. Төлбөрийн 80 хувийг шилжүүлсэн болно.
3. Энэ оны 12 дугаар сарын 15-ны дотор гэрээний хавсралтад заасан дараах ажлыг дуусгахыг аудитын консорциумд зөвлөмж болгосныг хүлээж авав:
 - a. хандив тусламжийн судалгааг нэг бүрчилэн тусад нь гаргах;
 - b. төлбөр орлогын задаргааг аймаг, төрийн байгууллагаар гаргах;
 - c. компани, төрийн байгууллагуудтай холбогдон гарсан зөрүүнүүдийг шийдвэрлэх арга замын талаар санал боловсруулах;
4. Ашигт малтмалын нөөц, тусгай зөвшөөрөл, үйлдвэрлэл зэрэг ерөнхий мэдээллийг холбогдох мэргэжлийн байгууллагуудын мэдээллийн сантай тулган нягталж, эх сурвалжийн хамтаар эцэслэн боловсруулж, хэвлэн нийтлүүлэхэд бэлтгэхийг санал болгосныг хүлээн авав.
5. Ажлын хэсгийн хуралдаанд гишүүд, түүнийг орлож ирсэн төлөөллүүд аудитын консорциумаас гаргасан Монгол Улсын ОУИТБС-ын 2012 оны нэгтгэл тайланд тусгагдсан асуудал, зөвлөмжийн төслийг удирдлагадаа танилцуулж, зөвшөөрч байгаа эсэхийг албажуулж өөрийн төлөөллийн ахлагчид хүргүүлэх, төлөөллийн ахлагч нар бусад гишүүдийнхээ саналыг нэгтгэн эцэслэж Ажлын албанд 12 дугаар сарын 6-ны дотор хүргүүлэхийг төлөөллийн ахлагч нарт даалгав. Гишүүд энэ тухай удирдлагадаа танилцуулсан байна.
6. ОУИТБС-ын 2012 оны нэгтгэл тайлан гаргах явцад тулгарсан бэрхшээл, илэрсэн зөрчил, алдаа сургамж бүрийг ажлын хэсгийн бүрэлдэхүүнд гишүүд нь оролцдог байгууллага, аж ахуйн нэгж бүрээр судалж, өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлыг тухайн байгууллага, аж ахуйн нэгжүүд дотоод ажлын төлөвлөгөөнд тусгаж ажиллахыг Ажлын хэсгийн гишүүдэд даалгав.
7. ОУИТБС-ын 2013 оны төлөвлөгөөний биелэлтэд Ажлын хэсгийн гишүүдээс хуралдаан дээр гаргасан саналыг тусган Үндэсний зөвлөлд танилцуулахыг Ажлын албанд даалгав.
8. ОУИТБС-ын 2014 оны төлөвлөгөөний төсөлд Ажлын хэсгийн гишүүдээс хуралдаан дээр гаргасан саналыг тусган засч найруулан Үндэсний зөвлөлд танилцуулахыг Ажлын албанд даалгав.
9. ОУИТБС-ын Үндэсний тайланд аудитын консорциумын жил бүр өгсөн зөвлөмжийн давхардлыг судлаж, зөвлөмжийг биелүүлэх хүрээнд 2014 онд хэрэгжүүлэх боломжтой ажлын жагсаалтыг талууд бие даан хэлэлцэн зөвшилцөж, 2014 оны төлөвлөгөөний төсөлд тусгах саналыг төлөөллийн ахлагч нар 12 дугаар сарын 10-ны дотор Ажлын албанд хүргүүлэхээр харилцан тохиролцов.

2013 оны 12 дугаар сарын 13-ны өдөр

Хэлэлцсэн асуудал ба шийдвэрүүдийг сийрүүлэв. Үүнд:

1. Ажлын хэсгийн гишүүдийн саналыг нэгтгээд 2013 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 15 цагаас өмнө хүлээн авч нэгтгэн боловсруулаад Үндэсний зөвлөлд танилцуулахыг ТАН эвслийн зохицуулагч Н.Баярсайхан, ажлын албаны харилцааны мэргэжилтэн Б.Дэлгэрмаа нарт даалгав.
2. Судалгаа дуусаагүй учраас үүнийг судалгаа дууссаны дараа ажлын хэсгээр дахин хэлэлцэхээр хойшлуулав.
3. Хойшлуулсны дараа хэлэлцсэн асуудлаа Үндэсний зөвлөлд танилцуулж, батлуулах.
4. Ажлын хэсгийн гишүүдийн санал дүгнэлтийг тусгаад, судалгааг сайшаав.

2014 оны 3 дугаар сарын 11-ний өдөр

Хэлэлцсэн асуудал ба шийдвэрүүдийг сийрүүлэв. Үүнд:

1. Монголын АйСиЖи компаниас боловсруулсан Монголын ОУИТБС-ын стратеги төлөвлөгөө, түүний ажлыг төлөвлөгөөг дэмжин хүлээн авч хэрэгжүүлэхийн төлөө талууд хамтарч ажиллахаар тогтов.
2. Засгийн газар крмпаниудын тайлагналын явцыг ажлын хэсэг сонсож танилцлаа. Тайлагналын явцын тухай мэдээллийг хэвлэл мэдээлэлд нийтлүүлэхийг ажлын албанд даалгав. Холбогдох мэдээллийг сонинд тавьж нийтэд мэдээлсэн байна.
3. Ажлын хэсгийн гишүүдийн санал дүгнэлтийг тусган шинэчлэн найруулахаар тогтов.
4. Үнэт цаасны тухай хуулийн 4.1.26-д “бенефициар өмчлөгч” гэж зааснаар тогтов.
5. ОУИТБС-ыг хэрэгжүүлэхэд идэвхи санаачилгатай ажиллаж буй төр, засгийн байгууллагад гурван зуун мянган төгрөг, иргэний нийгмийн байгууллагуудад долоон зуун мянган төгрөг, ажлын албанд гурван зуун арван зургаан мянга гурван зуун төгрөгийг урамшуулал болгон тус тус олгосугай.

1.2.Монголын ОУИТБС-ын 2012 оны нэгтгэл тайлангийн тойм

Монгол Улсын ОУИТБС-ын 2012 оны аудитын нэгтгэлийг хийж гүйцэтгэхээр Их Британийн Мооре Стефенс, Монголын Далайван аудит компани шалгарч, гэрээт ажлаа 2013 оны 7 дугаар сарын сүүлчээр эхлүүлсэн. Энэ нэгтгэлд 200 компанийн төлбөр, тэднээс Засгийн газрын хүлээн авсан орлогын аудитын нэгтгэлийг явуулж, 2013 оны 12 дүгээр сарын эхээр дуусгаж, Ажлын хэсгээр 2 удаа хэлэлцүүлж, Үндэсний зөвлөл 12 дүгээр сарын 23-ны хуралдаанаар Монгол Улсын нэгтгэл тайланг эцэслэн хэлэлцэж баталсан байна.

Ерөнхий хэсэг

2012 онд олборлох салбар нь дотоодын нийт аж үйлдвэрийн бүтээгдэхүүний 67%, дотоодын нийт бүтээгдэхүүний 18%, нийт экспортын 90%-ийг бүрдүүлсэн байна.

Газрын тос. Газрын тосны үйлдвэрлэл 1998 онд сэргэснээс хойш 10.58 сая баррел газрын тос үйлдвэрлэн үүнээс 9,89 сая баррелыг Хятадад гаргасан бөгөөд Монгол улсад боловсруулах үйлдвэргүйн улмаас түүхийгээр нь гаргажээ. 2010 онд Монгол улс нь газрын тос үйлдвэрлэгч орон хэмээн зарлагдсан бөгөөд 19 дүгээр талбай болон 97`PSC талбай нь баталгаат 272 сая тонн нөөцтэй хэмээн тогтоогджээ.

Одоогоор Монгол улсад үйлдвэрлэл явуулж буй хоёр сав газар буй бөгөөд нэг нь зүүн өмнөд Говь нутагт орших Зүүнбаян бөгөөд энэ бүсэд 1953 оноос хойш 1969 он хүртэл олборлолт явуулж, улмаар 2007 оноос дахин эхлүүлэн 2012 оны 2 сарын 29-ний байдлаар 2.66 сая тонныг

олборлоод байна. Тамсагийн сав газарт 1998 оноос үйлдвэрлэл эхлүүлсэн бөгөөд одоогоор олборлолт хамгийн идэвхтэй явагдаж байна. Тамсагт хийсэн үнэлгээгээр тус газрын нөөцийг 2011 оны байдлаар 2.07 сая тонн хэмээн тооцсон байна. 2012 онд Монгол улсын түүхий тосны үйлдвэрлэл 3.6 сая тонн гарч, жил тутамд 10%-иар өсөж байна.

Нүүрс. Монгол улс нь нүүрсний нөөцөөрөө дэлхийд эхний 10-т багтдаг орны нэг юм. Геологийн боломжит нүүрсний нийт хэмжээ нь 173.3 тэрбум тонн бөгөөд дэлхий дээрх нээгдсэн бүхий л ордын нөөцийн 10%-тай тэнцүү, 21.5 тэрбум тонны баталгаат нөөцтэй юм. Монгол улс нь 2012 онд 31 сая тонн нүүрс олборлож үүнээс 20.9 сая тонныг нь экспортлосон бөгөөд нүүрсний экспорт нь нийт экспортын 47%-ийг эзэлж, нийт 1.9 тэрбум төгрөгийн нүүрс гадагш борлуулсан байна.

Зэс. Монгол улсын тогтоогдсон зэсийн нийт нөөц нь 84.1 сая тонн бөгөөд Монгол улс нь зэсийн нөөцөөрөө дэлхийд дээгүүрт ордог. 2012 онд Монгол улсын зэсийн баяжмалын экспортын хэмжээ 574 мянган тоннд хүрсэн байна. Монгол улсад Эрдэнэт, Оюу толгой гэсэн хоёр том уурхай үйл ажиллагаа явуулж байна³.

Алт. Монгол улс нь 2012 онд 6 тонн орчим алт олборлосон бөгөөд үүнээс 2.8 тонныг экспортод гарган 122 сая ам долларын орлого олсон байна. Бороогийн уурхай нь Улаанбаатар хотоос 100 орчим км зайтай орших бөгөөд тус орд дээр 2003 оноос хойш олборлолт явуулан нөөц нь дуусах дөхөөд байна. Тус уурхай нь Монголд үйл ажиллагаа явуулж буй үндсэн ордын нэг юм. Үүний зэрэгцээ Оюу Толгой нь 1800 тонн алтны нөөцтэй. Харин шороон орд дээр ажилладаг жижиг олборлогчид Монгол улсын алтны үйлдвэрлэлийн дийлэнх хувийг эзэлж байжээ. Байгаль орчны асуудлуудаас үүдэн 2009 онд усны эх, сав газар болон ойн нөөц бүхий газарт алт олборлохыг хориглосон хуулийг батлан гаргасан байна⁴.

Уран. Монгол улсад ураны хэд хэдэн томоохон орд газрууд буй бөгөөд эдгээрийн таамаг нөөц нь 30- 62 мянган тонноор хэмжигдэж буй юм. Монгол Улсад стратегийн ач холбогдол бүхий 15 орд газар бүртгэгдсэний дотор Мардайн орд, Дорнод аймгийн Дашбалбар суман дахь Дорнодын орд зэрэг ураны 2 орд байна. Одоогоор Монгол улс нь уран экспортлохгүй байна. Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Цөмийн энергийн газрын мэдээгээр 15 компани тусгай зөвшөөрлийн төлбөрт 2.9 тэрбум төгрөгийг төлжээ⁵. Монгол улс нь одоо алт, зэс, молибден, уран зэрэг ашигт малтмал олборлогч чухал орон болоод байна.

2012 оны ОУИТБС-ын тайлангаа ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч 1514 компани, газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээ бүхий 11 компани, цацраг идэвхт ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч 6 компани нийт 1531 компани гаргаж, Засгийн газар 1829 компаниас хүлээн авсан орлогоор тайлангаа гаргасан юм.

Нэгтгэл тайланд хамрагдсан 200 компаниудаас 2012 онд хамгийн их орлого төвлөрүүлсэн компани нь уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэр бөгөөд тэрээр 519,7 тэрбум төгрөг, удаад нь Оюу толгой 201,9 тэрбум, Энержи ресурс 111,9 тэрбум, Петрочайна Дачин Тамсаг 104,8 тэрбум МАК 86,1 тэрбум, Эрдэнэс МГЛ 80,1 тэрбум, Тавантолгой 58,5 тэрбум, Болд төмөр Ерөө гол 37,9 тэрбум, Саусгоби сэндс 37,7 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлжээ.

Нэгтгэл тайланд 40 сая төгрөгөөс дээш татвар, төлбөр төлсөн 200 компанийн тайланг хамруулан, нэгтгэхэд 2012 оны улсын төсөвт 1 их наяд 594 тэрбум төгрөгийн татвар, төлбөр төлснийг буюу

³Эх сурвалж: УСГ.

⁴Эх сурвалж: АМГ.

⁵Эх сурвалж: Цөмийн энергийн газар 2013.10.28.

урсгал орлогын 33 хувийг бүрдүүлж байжээ. Татварын нэр төрлөөр нь үзэхэд нэгтгэгдсэн дүнгийн 32%-ийг ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр болон нэмэлт төлбөр, 13,75%-ийг НӨАТ, 12,07%-ийг ААНОАТ тус тус бүрдүүлжээ.

Төв, орон нутгийн төлбөр орлогын нэгтгэл

Аудитаар баталгаажсан компаниудын төлсөн төлбөрийн нийт дүнгийн 93% нь улсын төсөвт, 6% нь орон нутгийн төсөвт, 1% нь төр засгийн байгууллагуудад хандив, дэмжлэгийн орлогыг бүрдүүлсэн байна.

Орон нутагт төлөгдсөн нийт 73 тэрбум 848 сая төгрөгийн 67% нь Өмнөговь аймагт, 14% нь Орхон аймагт, 9% нь Булган аймагт тус тус төвлөрсөн байна.

Хандив, нөхөн сэргээлтийн дүн

Төрийн байгууллагуудад өгсөн 14,518,876 мянган төгрөгийн хандив тусламжийн 39%-ийг (5,6 тэрбум төг) Эрүүл мэндийн яам, 27%-ийг (3,8 тэрбум төг) Өмнөговь аймаг, 8%-ийг (1,1 тэрбум төг) Ховд аймаг, 8%-ийг (1,1 тэрбум төг) Сэлэнгэ аймаг дангаар хүлээн авсан байх ба үлдэх 20%-ийг (2,7 тэрбум төг) бусад аймаг, төрийн байгууллагууд хүлээн авсан байна. Төрийн байгууллагад өгсөн хандив дэмжлэгийн дүн 26 тэрбум төгрөг болж нэгтгэгдсэн бол байгаль хамгаалах зардлын урьдчилгаа 1,2 тэрбум байсны

Тайлбарлагдаагүй зөрүүний байдал

Засгийн газрын хүлээн авсан дүн, компанийн төлсөн дүнг тулган шалгахад 2012 онд 360,9 сая төгрөгийн тайлбарлагдаагүй цэвэр зөрүү үүссэн бөгөөд зөрүү бүрийн шалтгааныг нэгтгэлийн тайланд тодорхой дурьдсан байна. Компани тайлан ирүүлээгүй, Засгийн газраас ирсэн баримт нь тайлантай тохирохгүй, Компани дэлгэрэнгүй мэдээлэл өгөөгүй, Засгийн газар дэлгэрэнгүй мэдээлэл өгөөгүй, Компани төлсөн татвараа тайлагнаагүй, Засгийн газар хүлээн авсан тайлангаа тайлагнаагүй, Дэлгэрэнгүй мэдээлэл ирсэн боловч ашиглах боломжгүй, ойлгомжгүй, Ханшийн зөрүү, Материаллаг бус дүн байсныг нотолсон байна.

Үндэсний зөвлөл нэгтгэл тайланг баталж, зөрүүтэй холбогдох компани, төрийн байгууллагууд зөрүүний тайлбараа 2014 оны 1 дүгээр сарын 31-ний дотор нийтэд мэдээлэх нь зүйтэй гэж онцолжээ. 2012 оны тайлангаар зөрүүний талаар сонирхолтой тойм гаргасан байна.

Ажлын албанаас зөрүү бүхий 43 байгууллагад албан тоот илгээж, тайлбар өгөхийг хүсснээс 20 нь хариу ирүүлсэн байна. Бусад хариу огт өгөөгүй байна.

Уулын ажлын төлөвлөгөөний биелэлт

Нэгтгэлд уулын ажлын төлөвлөгөөний биелэлтийн судалгааг оруулж өгсөн байна. Уг төлөвлөгөөг хөрс хуулалт, хүдэр олборлолт, хүдэр боловсруулалт, бүтээгдэхүүн гаргалт, бүтээгдэхүүн борлуулалт гэсэн үзүүлэлт, ашигт малтмалын нэр төрөл, хамрагдсан компанийн нэрээр гаргасан байна. Ажлын даалгаварт зааснаар нэгтгэл тайланд хамрагдсан нийт 200 компанийн судалгааг гаргах байснаас 84 компанийн уулын ажлын төлөвлөгөөний биелэлтийг гаргасан байна.

Алт олборлодог 32, нүүрс олборлодог 24 компаниар уулын ажлын төлөвлөгөөний биелэлтээ гаргаж ирүүлжээ.

Нөхөн сэргээлтийн ажил

Нэгтгэлд байгаль орчиныг хамгаалах, нөхөн сэргээлтийн мэдээг хамруулахаас 71 компани мэдээллээ өгсөг бөгөөд техникийн нөхөн сэргээлтийн хүрээнд 504,2, шимт хөрсний нөхөн сэргээлтэд 334,1, биологийн нөхөн сэргээлтэд 263,3 га газрыг хамруулж, 11 сая төгрөг зарцуулсан байна.

Байгаль орчиныг хамгаалах дансанд нөхөн сэргээлтийн урьдчилгааны 50 хувийн тооцоонд 45 компани 1,4 тэрбум төгрөгийг төвлөрүүлсэн байна. Үүнээс 1 л компани урьд оныхоо урьдчилгаа 15,7 сая төгрөгийг буцаан авсан байна.

Тусгай зөвшөөрлийн судалгаа

Монгол Улсад 2012 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар ашигт малтмалын 1823 тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж бүртгэгдсэнээс ОҮИТБС-ын 2012 оны тайлангаа гаргаагүй 323 аж ахуйн нэгжийн нэрсийн жагсаалтыг Ашигт малтмалын газраас Мэргэжлийн хяналтын ерөнхий газарт хүргүүлж, хуулийн зохих хариуцлага тооцохыг уламжилсан байна.

2012 оны эцсийн байдлаар нийт 1853 компани ашиглалтын 1237, хайгуулын 2303 тусгай зөвшөөрөл, буюу нийт 3540 тусгай зөвшөөрлийг, ураны 14 компани цацраг идэвхит ашигт малтмалын 70 тусгай зөвшөөрөл, газрын тосны 16 компани нь 20 Бүтээгдэхүүн хуваах гэрээ эзэмшиж байна. Тусгай зөвшөөрөл эзэмшиж байгаагаар нь судалгаа хийхэд Алтан дорнод Монгол 63, Монголросцветмет 34, МАК 34, Сентеррагоулд 33, Гобикоул энд энерги 28, Тейс майнинг 27, Гацуурт 25, Пибодивинсвей ресорсиз 23, Тэнритерра ресурс 23 тусгай зөвшөөрөлтэй байв.

Аудит нягтлан бодохын бүртгэлийн олон улсын стандартын хэрэгжилт

Нэгтгэлээр 200 компаниудад нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, аудитын олон улсын стандарт хэрэгжсэн эсэхийг судлан гаргаснаас 196 нь уг стандартуудыг хэрэгжүүлдэг ба харин ОҮИТБС-ын тайлангаа аудитороор баталгаажуулсан эсэхийг нь хянахад хангалтгүй байсан ажээ.

Өмчлөлийн хэлбэр

Нэгтгэлд оролцсон 200 компанийн өмчлөлийн хэлбэрээр судлан үзэхэд 25 нь гадаадын хөрөнгө оруулалттай, 5 төрийн өмчийн оролцоотой байсныг тогтоов. Дийлэнх олонхи нь хувийн хэвшлийн компани байна.

Орон нутгийн гэрээний байдал

Олборлох үйлдвэрлэлийн компаниудаас нутгийн удирдлагатай байгуулсан хамтран ажиллах гэрээ, ус ашиглах гэрээ, газар ашиглах гэрээ болон бусад гэрээнүүдийн талаар мэдээлэл авч судалгааг гаргасан байна. Компаниудаас 149 нь дурдсан гэрээ байдаг талаар мэдээллээ ирүүлсэн байна. Харин гэрээний талаархи дэлгэрэнгүй мэдээллийг зөвхөн 32 компани нийт 132 гэрээ ирүүлснээс 4 нь байгаль орчныг хамгаалах, хууль тогтоомжийг хэрэгжүүлж, ажиллах тухай, 22 нь нийгмийн хариуцлагын чиглэлээр хамтран ажиллах тухай, 21 нь ус ашиглах тухай, 83 нь газар эзэмшүүлэх тухай, үлдсэн нь бусад агуулгатай байжээ.

Монголын ОҮИТБС-ын 2012 оны нэгтгэл тайлангийн зөвлөмжүүд

A. Хамрах хүрээний судалгааг хэрэгжүүлээгүй

a. Материаллаг байдал

Материаллаг байдлыг 2010 оны 6 дугаар сард Үндэсний зөвлөл батласанаас хойш дахин өөрчилж, шинэчлээгүйгээс материаллаг бус төлбөр, орлого, болон олборлох салбарын бус компаниуд нэгтгэл тохиолдол гарсан байна. Энэ үнэний ортой бөгөөд 2014 оны тайлагнах болон цахим тайлагналын системийг бий болгох хүрээнд цэгцлэх болно.

b. Компаниуд

Олборох салбарын бус 7 компани нэгтгэлд орсон нь үнэн. 2011 оны ОУИТБС-ын дүрмээр олборлох салбарт ажиллаж буй бүх компани, эсхүл тусгай зөвшөөрөлтэй бүх компаниуд тайлагнах үүрэгтэй болон тухайн компаниудын төлбөрийн дүн нь босгоос давсан тул нэгтгэлд хамрагдсан. Үүнийг цаашид аль болох давтахгүй чиглэлээр ажиллаж байна.

c. Орлогын урсгал

Зарим нэг төлбөр, хандивыг хянаж, өөрчлөх хэрэгтэй байна. Тухайлбал, зарим хандивыг заавал тайлагнах хэсэгт оруулсан нь буруу учир хасах, яагаад гэвэл түүний зааварчилгаа нь ойлгомжгүй, мөнгөн болон мөнгөн бус гэдгээр нь хэрхэн ангилах нь ойлгомжгүй байна. Заримыг орлого гээд хүлээн авахад ч боломгүй зүйл байна. Буруу ангилж, муйхарласанаас улбаалж зөрүү нэмэгдэж байна. Иймээс бүх төлбөр орлого гэснийг эргэн харж, 2014 оны тайлагналын цар хүрээг цахим тайлагналын холбож тодорхойлох нь зүйтэй байна.

d. Тайлангийн маягтууд

Ийм олон тооны ижил утгатай маягт шаардлагагүй байна. Маягт нь ижилсиж, цөөрснөөр харин түүнд хавсарган ирүүлэх тайлбар, бусад материалыг дагалдуулах х чухалтай байна. Энэ үнэний ортой бөгөөд 2014 оны тайлагнах болон цахим тайлагналын системийг бий болгох хүрээнд цэгцлэх болно.

B. ОУИТБС-ын ойлголт муу, хүсэл эрмэлзлэл сул

Монголын ОУИТБС нь сурталчилгааны ажлаа улам идвэхжүүлж, тайлагнах тухай мэдээлэл, тэдгээрийн зааварчилгааг компани бүрт хүргэж идэвхтэй ажиллах шаардлагатай. Түүний дараа хариуцлага ярих ёстой болов уу. Энэ үнэний ортой бөгөөд 2014 онд батлагдсан Монголын ОУИТБС-ын стратегийн баримт бичгийн хүрээнд хийх ажлыг улам идэхжүүлэх хэрэгтэй байна.

C. Тайлангийн маягтыг хангалттай түвшинд бэлтгэн гаргаагүй

Засгийн газар, Компани 2 талаас тайлангаа муу гаргаж байна. Тийм учир сургалт сурталчилгааны ажлыг сайжруулснаар энэ байдлыг засах боломжтой гэж үзэж байна. Энэ үнэний ортой бөгөөд 2014 онд батлагдсан Монголын ОУИТБС-ын стратегийн баримт бичгийн хүрээнд хийх ажлыг улам идэхжүүлэх хэрэгтэй байна.

D. Эрх зүй, татварын орчин хангалттай бүрдээгүй

Хууль эрх зүй, татварын орчиныг сайжруулахгүй бол саад бэрхшээл байсаар л байна. Энэ үнэний ортой бөгөөд Засгийн газар, Уул уурхайн яам, Сангийн яам, Хууль зүйн яам, Монголын ОУИТБС нь хууль эрхүйн орчиныг тодорхой болгох тууштай ажиллаж хуулийн төсөл боловсруулаад байна. Хуулийн төслийг эрдэс баялагийн салбарын ил тод байдлын тухай гэсэн байдлаар боловсруулад Улын Их хуралд өргөн барихад бэлэн болоод байна.

а. Төлбөр тооцооны төвлөрсөн сиситем дутагдалтай

Төрийн авах ёстой татвар, төлбөр, хураамжийг яам агентлагууд болон орон нутаг цуглуулж байна. Ойролцоогоор 100 гаруй байгууллага оролцож байна. Энэ үнэний ортой бөгөөд Монголын ОУИТБС нь орлого төвлөрүүлэх ажлыг сайжруулахдаа гарч буй алдаа, дутагдлыг засахад туслах аргаар ажиллах ёстой. Аль болох цахимжуулж, хүний хүчин зүйлийг багасгах ёстой юм.

б. Татвар төлөгчийн дугаар байхгүй

Монгол Улсад татвар төлөгчийн бүртгэлийн дугаар байхгүй байна. ААН, компаниуд дээр ч мөн адил. Зөвхөн компанийн бүртгэлийн дугаараар зохицуулж байна. Гэвч үүсгэн байгуулагч компани, салбар компаниуд бие биеийнхээ өмнөөс төлбөр төлөх практик их байгаа нөхцөлд ойлгомжгшгүй, зөрүүтэй байдал байсаар л байна. Энэ үнэний ортой бөгөөд Монголын ОУИТБС нь орлого төвлөрүүлэх ажлыг сайжруулахдаа гарч буй алдаа, дутагдлыг засахад туслах аргаар ажиллах ёстой. Аль болох цахимжуулж, хүний хүчин зүйлийг багасгах ёстой юм.

Е. Тайлангууд нь аудитаар баталгаажуулаагүй

ОУИТБС-ын тайланг аудитаар баталгаажуулж байгаа нь хэт сул, үүнийг засах ёстой. Энэ үнэний ортой бөгөөд энэ ажлыг сургалт сурталчилгааны ажлаар засч болно гэж үзэж байна.

Ү. Мэдээлэл холбоо харилцааг сайжруулах

Монголын ОУИТБС-ын мэдээлэл, холбоо харилцааг зайлшгүй сайжруулах ёстой, үүнд Ажлын албаны цахим сэтгүүлийн англи хэл дээрх хэсгийг илүү сайжруулах ёстой. Сайжруулах хүрээнд холбоо харилцааны мэргэжилтэн, мэдээллийн технологийн ажилтаныг ажиллуулж байна.

Г. ОУИТБС-ын мэдээллийн сан дутмаг

ОУИТБС-ын хүрээнд бий болж байгаа мэдээллийн санг баяжуулах ажлыг Ажлын ала хэрэгжүүлэх ёстой. Энэ үнэний ортой бөгөөд энэ ажлыг Ажлын алба байнга анхаарч ажиллах ёстой гэж үзэж байна.

Н. Ажлын албаны чадавхи сул

Ажлын албаны чадавхи, үйл ажиллагаа сул хэвээр байна. Энэ үнэний ортой бөгөөд Ажлын албыг шинэ хуулийн хүрээнд шинэчлэн зохион байгуулж, орон тоог нэмэгдүүлэн ажиллах ёстой гэж үзэж байна.

И. Аудитын нэгтгэлийн хугацаа

Нэгтгэлийн хугацаа байнга амралтын хугацаатай давхцаж байдагийг эргэн харж сайжруулах хэрэгтэй байна. Энэ үнэний ортой бөгөөд хугацааг сайтар төлөвлөж ажиллах үүргийг Ажлын алба

хүлээж байгаа. Цахим тайлагналыг хэрэгжүүлснээр нэгтгэлийн хугацааг багасгах бололцоотой болно.

Ж. Урьд жилүүдийн зөвлөмжүүдийн хэрэгжилт

Ихэнхэ асуудал болон зөвлөмжүүдийг урьд жилүүдийн ОУИТБС-ын тайланд өгч байсан. Хэрэв өмнөх жилүүдийн зөвлөмжүүдийг хэрэгжүүлсэн бол аудитын нэгтгэл хийх үеэр гарч ирсэн асуудлаас зайлсхийх боломжтой байсан. Зөвлөмж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөтэй байх ёстой. Эгнэ үнэний ортой бөгөөд шинэ хууль, цахим тайлагналын хүрээнд зөвлөмжөөр өгөгдсөн олон асуудлыг шийдвэрлэх бололцоотой Монголын ОУИТБС үзэж байна.

1.3 Монголын ОУИТБС-ын 2013 оны нэгтгэл тайлан гаргах аудитын консерциум сонгон шалгаруулах ажлын явц

Монголын ОУИТБС-ын 2013 оны нэгтгэл тайлан гаргах аудитын консерциум шалгаруулах удирдамжийг 2014 оны 3 дугаар сарын эхээр Засгийн газрын хэрэг эрхлэх газраас батлуулж, Үнэлгээний хороог байгуулсан байна. Удирдамжийг боловсруулахад Монголын ОУИТБС-ын ажлын хэсгийн гишүүдийг оролцуулж, цахим сүлжээг ашигласан бөгөөд эцэст нь Үнэлгээний хорооноос нэмэлт өөрчлөлт оруулж, ОУИТБС-ын 2013 оны шинэ стандартын шаардлагуудыг оруулсан байна.

Сонгон шалгаруулалтыг 2014 оны 3 дугаар сараас эхлэн явуулж, сонгон шалгаруулалтыг 5 дугаар сарын эцсээр дуусгаж, Улаанбаатар аудит, Харт Нойрс Монгол/Их Британи улсын консерциум шалгарсан боловч Их Британийн Мооре Стефенс, Монголын Далайван аудит компаниудын консерциум гомдол гаргасан байна. Гомдлын агуулга нь техникийн саналын үнэлгээнд эргэлзэж байгаагаа илэрхийлж, дахин үнэлгээ хийж өгөхийг хүссэн байна.

1.4 Компани болон Засгийн газрын ОУИТБС-ын 2013 оны тайлан гаргах ажлыг зохион байгуулсан нь

ОУИТБС-ын ажлын алба Ашигт малтмалын газартай хамтран ажиллаж, сургалт зохион байгуулж, сонин, цахим сүлжээгээр сурталчилгаа хийж ажилласаны үр дүнд ашигт малтмалын 1188, газрын тосны 8, ураны 2 компани, нийт 1198 орчим компани 2013 оны тайлангаа 2014 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөр гаргасан байна.

Засгийн газрын ОУИТБС-ын 2013 оны тайланг гаргах асуудлаар Ажлын алба зохих байгууллагуудтай хамтран ажиллаж, Засгийн газрын тайланг 5 дугаар сарын 12-нд 1617 компаниар гаргуулсан байна.

Ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжүүдийн үнэмлэхүй олонхийг хамруулж чадсан байна.

2013 онд ОУИТБС-ын талаар 700 гаруй хүнд сургалт сурталчилгааг Улаанбаатар, Дархан-уул, Ховд, Говь-Алтай, Хэнтийд зохион байгуулж, 25 сургагч багштай болж, 20 гаруй хэвлэл мэдээллийн ажилтнуудыг сургасан байна. Сургалтын үр дүнд тайлан гаргах компанийн тоо эрс нэмэгдэж, 400 гаруйгаас 1500 болсон байна. Компани, төр засгийн байгууллагын удирдах ажилтнуудын хариуцлага нэмэгдэж, 1800 гаруй компаниас хүлээн авсан орлогоор тайлангаа гаргасан байна.

2013 оны 5 дугаар сард Австралийн Сиднейд зохиогдсон олон улсын ээлжит бага хурлаас ОУИТБС-ыг шинэчилж, дан ганц орлого төлбөрийн ил тод байдал гэлгүйгээр нэмэлт шаардлагуудыг хэрэгжүүлэгч орнуудад тавьж, үр дүнг 2015 онд үнэлж, дүгнэхээр тогтсон юм. ОУИТБС-д тусгай зөвшөөрөл, гэрээний ил тод байдал, олборлох үйлдвэрлэлийн хувь нэмэр, хөрөнгө оруулалт, хайгуул, төсөл, нөлөө бүхий хувьцаа, улсын төсвийн зарцуулалт, орон нутгийн шилжүүлгийг бүхэлд нь хамруулж, хууль эрхзүйн орчиныг нь тодорхой болгохыг шаардсан байна. Монголын ОУИТБС-ын 2014 оны ажлын төлөвлөгөөний гол анхаарал нь хүрсэн түвшингээ бататган бэхжүүлж, олон улсын шинэ шаардлагуудыг нэвтрүүлэхэд оршиж байна. Мөн ОУИТБС-ын удаа дараагийн нэгтгэл тайлангуудаар гараад байгаа зөвлөмжүүдийг зэрэгцүүлэн судлахад анхаарч, цаашид бодлого боловсруулж, шийдвэр гаргахад ашигладаг хэрэгсэл болгохын төлөө ажиллана.

2013-2014 онуудад ОУИТБС-ын аймаг, нийслэлийн салбар зөвлөлийг шинээр зохион байгуулж, 19 аймаг, нийслэлд салбар зөвлөлийг байгуулаад байна.

2013 оны үйл ажиллагааны үндэс нь орон нутаг дахь дэд зөвлөлийг шинэчлэн байгуулах, үйл ажиллагааны хөтөлбөр, төлөвлөгөөтэй болгоход чиглэж, холбогдох арга хэмжээ зохион байгуулж ирсэн бөгөөд эцэст нь 2014 оны 4 дүгээр сард зөвлөлдөх ажил хэрэгч уулзалтыг зохион байгуулсан. Аймгийн дэд зөвлөлүүд 2014-2015 оны ажлын төлөвлөгөөтэй болсон байна.

Сумын түвшинд салбар зөвлөл байгуулах ажлыг эхлүүлээд байна. Өмнөговь аймгийн Ханбогд, Цогтцэций сумдын салбар зөвлөлийг идэвхжүүлэх, Төв аймгийн Заамар суманд зөвлөл байгуулах практик арга хэмжээ авч ажилласан.

1.5 ОУИТБС-ын тайлагнал, шинэлэг алхам

Тайланг гаргаж, нэгтгэл тайланд орж байгаа компаниудын тоо жил бүр нэмэгдэж, зөрүү жил бүр буурч байна.

Он	Тайлан гаргасан компани	Сангийн яамнаас гаргасан Засгийн газрын тайланд хамрагдсан компанийн тоот	Монгол Улсын нэгтгэл тайланд орсон компани	Тайлбарлагдаагүй зөрүү
2006	64	137	25	4 тэрбум төгрөг
2007	102	184	38	775 сая төгрөг
2008	115	184	46	425 сая төгрөг
2009	129	363	101	58 сая төгрөг
2010	274	477	150	360 мянган төгрөг
2011	301	518	200	75 сая төгрөг
2012	1529	1829	200	360 сая төгрөг
2013	1198	1617	250	

Монгол Улсын ОУИТБС-ын 2013 оны нэгтгэл тайлангийн хүрээнд олборлосон, борлуулсан эрдсийн түүхий эд, ашигт малтмалын бүтээгдэхүүний тоо хэмжээ, уулын ажлын төлөвлөгөөний биелэлт, тусгай зөвшөөрлийн хөдөлгөөний талаар тойм судалгааг нэгтгэл орсон компаниудаар гаргасан байна.

1.6 Олон нийтийн мэдлэг ойлголтыг дээшлүүлэх, чадавхи бэхжүүлэх үйл ажиллагаа

Орон нутгийн түвшинд ОУИТБС-ыг хэрэгжүүлэх, дэд зөвлөлийн үйл ажиллагааг идэвхжүүлэх хүрээнд:

2013 оны 5 сарын 17-нд Ерөнхий сайдын ахлах зөвлөх Л.Гансүхээс бүх аймгийн Засаг дарга нарт Засгийн газрын 2012 оны 222-р тогтоолын хэрэгжилтэнд анхаарч ажиллахыг, дэд зөвлөлөө шинэчлэн байгуулах тухай зөвлөмжийг, ОУИТБС-ын талаархи багц мэдээллийн хамт хүргүүлэв.

2013 оны 7 сарын 4-нд 13 аймгийн Засаг даргын орлогч/дэд зөвлөлийн дарга, уул уурхайн асуудал эрхэлсэн газар хэлтсийн дарга, мэргэжилтнүүд/дэд зөвлөлийн нарийн бичгийн дарга, орон нутгийн иргэний нийгмийн байгууллагуудын чадавхийг бэхжүүлэх, ОУИТБС-ын зорилго, үйл ажиллагааны талаархи мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх зорилго бүхий “Дэд зөвлөл ба иргэний нийгмийн оролцоо” сэдэвт сургалтыг УБ хотноо зохион байгуулав. Сургалтанд 11 аймгийн 47 төлөөлөгч оролцов. Сургалтанд зориулж дэд зөвлөлийн ажиллах журмын төслийг урьдчилан боловсруулж, оролцогчдоос санал, зөвлөмж авав.

ОУИТБС-ын анхдугаар бүсийн чуулгадыг 4 бүсэд хуваан баруун бүсийг Ховд аймагт 8 дугаар сарын 20-ны өдөр, зүүн бүсийг Хэнтий аймагт 10 дугаар сарын 25-ны өдөр, хойд бүсийг Дархан-уул аймагт 11 дүгээр сарын 27-ны өдөр, төвийн бүсийг Улаанбаатар хотод 11 дүгээр сарын 12-ны өдрүүдэд тус тус зохион байгуулав. Бүсийн чуулганд аймаг, сумдын засаг, захиргаа, иргэний нийгэм, иргэд, олборлох үйлдвэрлэлийн компанийн төлөөллүүдийг оролцуулж, нэг талаас ОУИТБС-ын шинэ стандарт, зорилго, ач холбогдлын талаар мэдээлэл хийх, нөгөө талаас орон нутагт ОУИТБС-ыг хэрэгжүүлэхэд дэд зөвлөлийн оновчтой бүтэц, зохион байгуулалт, ажлын уялдаа холбоо, ажлын чиглэлийн талаар санал солилцож, туршлага хуваалцав. 4 бүсийн чуулганд нийт 20 аймгийн 350 гаруй төлөөлөгчид оролцож ОУИТБС-ын талаар мэдлэг, мэдээлэл авсан болно.

2013 оны 6 сарын 7-ны өдөр Говь-Алтай аймгийн “ОУИТБС-ын анхдугаар чуулган”-ыг тус аймгийн иргэний нийгмийн байгууллагаас санаачилан зохион байгуулж, урилгаар Ажлын хэсгийн зарим гишүүд оролцож, ОУИТБС-ын ач холбогдол, зорилго, үйл ажиллагааны талаар мэдээлэл хийв. Чуулганд нийт 250 гаруй төлөөлөгчид оролцсон болно.

Дээрх бүсийн чуулгадаас гарсан санал, зөвлөмж, туршлагад тулгуурлан ОУИТБС-ын дэд зөвлөлийн ажиллах үлгэрчилсэн дүрмийг 2013 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн Үндэсний зөвлөлийн хуралдаанд танилцуулж батлуулав.

2014 оны 4 сарын 25-ны өдөр Улаанбаатар хотноо 21 аймгийн дэд зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга нарыг урьж “Үр дүнд чиглэсэн дэд зөвлөлийн үйл ажиллагаа” сэдэвт олон талт оролцогчдын зөвлөгөөнийг зохион байгуулав. Зөвлөгөөнөөр аймаг бүрийн 2014-2015 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний төсөл, санхүүжүүлэх боломжит хувилбаруудыг хэлэлцэж, санал солилцов. Аймаг бүр төлөвлөгөөний төслийг дахин хянан, боловсруулж ажлын албанд ирүүлэхээр тогтов. Зөвлөгөөнд 65 хүн оролцов.

2014 оны 5 сарын 8-ны өдөр Заамар суманд ОУИТБС-ын нээлттэй өдөрлөг, уулзалтыг зохион байгуулж, мэдээлэл хийв. Уулзалтанд 51 хүн оролцсон ба уг арга хэмжээг Ийгл ТВ-ийн оройн мэдээгээр олон нийтэд мэдээлэв.

Цаашид зорилтот сум, аймгийн төвд ОУИТБС-ыг өдөрлөг, хурлыг үргэлжлүүлэн зохион байгуулах, дэд зөвлөлийн гишүүдтэй харилцаа холбоо, хамтын ажиллагааг тогтмолжуулах чиглэлээр ажиллаж байна. Орон нутагт чиглэсэн нийт арга хэмжээний хүрээнд 813 хүнд мэдээлэл хийсэн байна.

Хэвлэл, мэдээлэл, олон нийтэд чиглэсэн ажлын хүрээнд:

2013 оны 6 сарын 4-ны өдөр Уул уурхайн яам, АСИ хамтран ОУИТБ-ын тухай хуулийн төслийг сурталчилах уулзалтыг Гадаад харилцааны яаманд зохион байгуулав.

2014 оны 2 сарын 12-нд Төрийн ордонд 2012 оны нэгтгэл тайлан баталсан тухай хэвлэлийн бага хурлыг зохион байгууллаа.

Харилцааны стратегийн дагуу олон нийтэд мэдээлэх ажлыг сайжруулах зорилгоор Монгол Масс медиа групптай хамтын ажиллагааны гэрээ байгуулж, Ийгл ТВ-ээр мэдээ нэвтрүүлэх, 12 удаагийн цуврал нэвтрүүлэг бэлтгэх, цацах, www.news.mn сайтад мэдээ байршуулах ажлыг хийж гүйцэтгэж байна.

Өдөр тутмын сонинд тайлан гаргасан болон гаргаагүй компаниудын нэрс, 2013 оны тайлагналын явцын талаар болон ОУИТБС-ын талаар нийтлэл хэвлэл нийтлүүлж байна.

Блүүмбэрг, ТВ9, ТВ8, Ийгл ТВ, Эко ТВ, зарим өдөр тутмын мэдээллийн цахим хуудсанд мэдээ байршуулж байна.

Монгол Улсад зохиогдсон олон улсын болон нийтийг хамарсан зарим арга хэмжээнүүдэд тогтмол оролцож байна. Тухайлбал, “Коултранс” олон улсын бага хурал, “Дискавер Монголиа” хөрөнгө оруулалтын чуулга уулзалт, “Уул уурхайн яамны нээлттэй өдөрлөг”-т оролцож ОУИТБС-ын тухай танилцуулга хийж, үзэсгэлэн гаргаж хэвшлээ.

Ажлын албаны цахим хуудсыг хэрэглэгчдэд илүү ойр, хэрэглэхэд ойлгомжтой болгон шинэчлэн сайжруулж байна. Ингэснээр цахим орчинд сошиал медиагаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хийх бэлтгэлийг хангаж байна.

Танилцуулах материал, тараах зурагт хуудасны агуулгыг шинэчлэн хэвлүүлсэн.

Дотоод харилцаа, холбоог сайжруулах хүрээнд:

Сургагч багш нарт зориулж мэдээллийг шуурхай солилцох, туршлага хуваалцах зорилго бүхий facebook бүлгийг нээж, ажиллуулж байна.

2014 оны 6 дугаар сараас эхлэн Ажлын хэсэг, дэд зөвлөлийн гишүүд, орон нутгийн иргэний нийгмийн байгууллагууд, компаниуд, төр засгийн байгууллагуудын төлөөлөлд ОУИТБС-ын сар бүрийн цахим сонин, мэдээг хүргүүлж байна.

Дэд зөвлөлийн нарийн бичгийн дарга, гишүүдтэй албан захидал болон утсаар тогтмол харилцаж, мэдээлэл солилцож байна.

Зарим хөгжлийн байгууллагуудтай хамтын ажиллагааг хөгжүүлэх хүрээнд уулзалтуудыг зохион байгуулж байна.

Гадаад арга хэмжээний хүрээнд:

Хоёр жил тутамд зохиогддог ОУИТБС-ын ээлжит бага хурал Австралийн Сидней хотноо 5 дугаар сард зохиогдож, Ажлын алба олон улсын нарийн бичгийн дарга нарын газар, оролцогч талуудтай хамтран Монголоос оролцогч 3 талын төлөөлөл бүхий 15 хүний бүрэлдэхүүнтэй томоохон төлөөлөгчдийг хуралд оролцуулж, үзэсгэлэн гаргаж, өөрсдийн хийж бүтээснийг танилцуулахаас гадна бусад орнуудын туршлагаас суралцах завшаан тохиосон байна.

Азербайжаны ОУИТБС-ын гишүүн иргэний нийгмийн байгууллагуудын санаачилгаар Монгол, Норвеги, Азербайжаны ОУИТБС-ын хэрэгжилтийг харьцуулан судлах олон улсын судалгааны багт Б.Дэлгэрмаа урилгаар орж ажиллаж, Монгол Улс дахь хэрэгжилтийг олон улсад танилцуулж, туршлага солилцов. Тайлан 2013 оны 9 дүгээр сард Баку хотноо очиж танилцуулсан болно.

2013 оны 10 дугаар сард Казакстан улсын нийслэл Астана хотноо зохиогдсон ОУИТБС-ын шинэ стандартыг танилцуулах уулзалтад Уул уурхайн яамны ахлах мэргэжилтэн Т.Зууннаст, Петрочайне Дачин Тамсаг Монгол компанийн захирал Б.Дэлгэрбаяр, Иргэний нийгмийн эвслийн хуульч Б.Батхишиг, Ажлын албаны зохицуулагч Ш.Цолмон нар оролцсон байна.

Хийсэн сургалтын арга хэмжээ

Компаниудад “тайлангаа чанартай гаргацгаая” сэдэвт сургалтыг 6 удаа зохион байгуулж нийт 273 хүн хамрагдсан байна.

ЕСБХБ-ны санхүүжилтээр Адам Смит Интернэйшнл хүрээлэнтэй хамтран 12 удаагийн сургалтыг зохион байгуулав. Үүнд: Сургагч багш бэлтгэх – 25 хүн, компаниудад 2 удаа - 45 хүн, иргэний нийгмийн байгууллагуудад 2 удаа -51 хүн, сэтгүүлчдэд 2 удаа – 56 хүн, төрийн захиргааны төв байгууллагуудад 1 удаа – 22 хүн, орон нутгийн захиргааны байгууллагад 1 удаа – 24 хүн, нэгдсэн семинар 1 удаа – 47 хүн, Ажлын хэсгийн гишүүдэд түншлэлийн сургалт 2 удаа – 24 хүн зэрэг нийт 12 удаагийн сургалтанд нийт 294 хүн хамрагдсан байна.

Хоёр. ОУИТБС-ын шаардлага бүрийг хангасан байдал, явц;

2.1. ОУИТБС-ын стандарт 2013 онд шинэчлэн батлагдаж гишүүн орнууд ОУИТБС-ыг өргөжүүлэх талаар томоохон үүрэг амлалт авсан байна. Үүний адил Монгол Улс холбогдох арга хэмжээ авч эхлэсэн байна.

2014 оны Ажлын төлөвлөгөөнд шинэ стандарттай холбогдолтой 11 ажил оруулсан байна. Олборлох үйлдвэрлэлийн улсын хэмжээний үндсэн мэдээлэл, үйлдвэрлэл, борлуулалт, тусгай зөвшөөрлийн олголт, хөдөлгөөний судалгаа, томоохон хайгуулын ажлуудын мэдээ, олборлох үйлдвэрлэлээс эдийн засагт оруулсан хуьт нэмрийн мэдээ, бүтээгдэхүүн хуваах гэрээний судалгаа, аймгуудад хүлээн авсан нийгмийн үйлчилгээ, дэд бүтцийн байгууламж болон шилжүүлгийн мэдээг 2012 оны эцсийн байдлаар гаргуулав. Эдгээр мэдээг 2012 оны нэгтгэл тайланд хавсралтаар оруулахыг бэлтгэж байна.

Мөн Монгол Улсад ил тод байдлын томоохон арга хэмжээ хийгдсний нэг нь 2013 оны 1 дүгээр сарын 1- нээс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэсэн Төсвийн тухай хуулиар Төсвийн тогтвортой байдлыг хангасан байх, Төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх, Санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх, Ил тод байдлыг хангасан, Хариуцлагатай байх гэсэн 5 зарчмыг баталж мөрдөж эхлэсэн байна.

Төсвийн ил тод байдлыг хангасан байх зарчмыг тодорхойлж, төсвийн бүх явцад олон нийтийг оролцуулах, саналыг авах, харгалзан үзэх, хяналт тавих боломжоор хангах, тэдэнд мэдээлж байхыг хуульчилж өгсөн.

Мөн зөвхөн эмнэлэг, бүх шатны боловсрол, соёлын үйлчилгээ үзүүлдэг төсвийн байгууллага хандив дэмжлэг авч болно. Төсвийн ерөнхийлөн захирагчийн авах тусламж, хандивын хэмжээ тухайн төсөвт байгууллагын батлагдсан төсвийн 50 хувиас хэтрэхгүй байна. Санхүүжүүлэх эх үүсвэр дутагдсан хөтөлбөр, арга хэмжээг үргэлжлүүлэх; байгууллагын хүний нөөцийн чадавхийг

бэхжүүлэхэд чиглэсэн сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх тохиолдолд төсвийн байгууллага төсвийн ерөнхийлөн захирагчаараа дамжуулан төрийн болон орон нутгийн өмчит бус хуулийн этгээдээс мөнгөн хөрөнгө, хөдлөх эд хөрөнгийн хэлбэрээр тусламж, хандив авч болно:

Төсвийн байгууллага хандив, тусламж авахыг хориглох тохиолдол нь хандив, тусламж өгсөн этгээд нь төсвийн байгууллагын хэрэгцээнд өөрийн барааг худалдах, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлдэг байх зэргээр шийдвэрлэгдсэн байна.

ОУИТБС-ын хэрэгжүүлсний үр дүнд Монгол Улсад шинэчлэлийн шаардлагыг ухамсарлан Улсын Их хурлаас баталсан 2014 оны 1 дүгээр сард “Төрөөс эрдэс баялагийн салбарт 2014-2025 он хүртэлх баримтлах бодлогын үндэслэлд 1.1.Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого нь хувийн хэвшилд түшиглэсэн, ил тод, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлж, ойрын болон дунд хугацаанд эдийн засгийн тэнцвэртэй олон тулгуурт бүтцийг бий болгож, үндэсний язгуур эрх ашгийг хангахад чиглэнэ. Нэг чухал зарчим ыатлагдсан нь эрдэс баялгийн салбарыг хөгжүүлэхэд төрийн байгууллага, аж ахуйн нэгж нээлттэй, ил тод, хариуцлагатай байх тухай юм.

Эрдэс баялгийн салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгох хүрээнд ил тод байдлын болон хариуцлагатай уул уурхай, нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөллийн үнэлгээ зэрэг олон улсын санаачилгыг дэмжин хөгжүүлнэ.

Олборлох салбарын хүрээнд баримтлах чилэл нь нэгдүгээрт, Монгол Улсын хөгжлийн цаашдын чиг хандлагатай уялдуулсан орчин үеийн, олон улсын стандартад нийцсэн, эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах, экспортын чиг хандлагатай, аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, байгаль орчныг хамгаалах шаардлагыг хангасан, ил тод, хариуцлагатай уул уурхайн олборлох болон боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлэх бодлого баримтлах; хоёрдугаарт, хүний эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатай техник, технологийг ашиглаж ил тод, хариуцлагатай уул уурхайн зарчимд нийцсэн үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжийг дэмжих;- ээр тус тус заасан байна.

Орон нутгийн хөгжлийг дэмжих, орон нутгийн иргэдийн эрх ашгийг хамгаалах хүрээнд нэгдүгээрт, тухайн нутаг дэвсгэрт уул уурхайн олборлолт эхлүүлэхийн өмнө хөрөнгө оруулагч, орон нутгийн иргэдийн хоорондын харилцан ойлголцох нөхцөлийг бүрдүүлэх, уул уурхайн төслийн нийгэм, эдийн засгийн ач холбогдлыг тайлбарлан таниулах ажилд орон нутгийн удирдлагын үүрэг, хариуцлагыг дээшлүүлэх; хоёрдугаарт, уул уурхайн олборлолтын хугацаанд нийгмийн хөгжилд дэмжлэг үзүүлэх зорилгоор хөрөнгө оруулагч компани, нутгийн өөрөө удирдах байгууллагын хооронд орон нутгийг хөгжүүлэх гэрээг ил тод байх, оролцооны зарчмыг баримтлан байгуулах-аар тус тус томъёолсон байна.

Эцэст нь уг баримт бичгийн “Эрдэс баялгийн салбарын удирдлага, зохион байгуулалт, хүний нөөцийн хүрээнд”төрийн байгууллагын үйлчилгээг сайжруулж, нээлттэй, ил тод, үр ашигтай болгох ба эрдэс баялгийн салбар хариуцсан Засгийн газрын бүх шатны байгууллагын ажлын тогтолцоо, зөвшөөрөл олголт, стандарт, хугацаа зэргийг нийтэд мэдээлж, иргэний нийгмийн хяналтыг тогтоох; - гэжээ.

Гурав. Баталгаажуулалтын зөвлөмжийн дагуу Үндэсний зөвлөл, Ажлын хэсгээс хэрэгжүүлсэн арга хэмжээний тойм;

3.1.Үндэсний зөвлөлийн хуралдаан

Монгол Улсын Ерөнхий сайдын ахалсан ОУИТБС-ын Үндэсний зөвлөлийн хуралдаан, түүнийг үйл ажиллагааг тогтмолжуулах ажил хийгдэж байна. Үндэсний зөвлөл 2013 онд 1 удаа хуралдсан нь үүний нотолгоо болж байна.

3.2.Ажлын хэсгийн хуралдаанууд

ОУИТБС-ыг хэрэгжүүлэх үүрэг бүхий Ажлын хэсгийн ээлжит хуралдаанууд 2013 оны сүүлийн хагаст 3, 2014 оны эхний хагаст 1 удаа зохиогдсон байна. Ажлын хэсгийн үйл ажиллагаа тогтмолжих хандлагатай байна гэж үзэж болно.

3.3.ОИТБС-ын тухай хуулийн төслийг боловсруулж байгаа нь

Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийн төсөл, түүний үзэл баримтлалыг боловсруулах чиг үүрэг бүхий ажлын хэсэг байгуулан ажиллуулж, үзэл баримтлал болон хуулийн төсөл боловсруулж, Хууль зүйн яаманд оруулж, үзэл баримтлалыг 2014 оны 5 дугаар сард батлуулсан байна.

Хуулийн төсөлд ОУИТБС-ын 2013 оны шинэ стандартын шаардлагуудыг бүхэлд нь оруулсан бөгөөд өөрийн улсын онцлог болох орон нутгийн дэд, салбар зөвлөлийн үйл ажиллагааны талаар зохих хуулийн томъёолол, санхүүжилт, зохион байгуулалтын бүтцийг оруулсан байна. 2014 оны намрын чуулганд хуулийн төслийг өргөн барихаар бэлтгэл ажлаа ханган ажиллаж байна.

3.4.ОУИТБС-ын санхүүгийн тогтвортой эх үүсвэрийн тухай

Монгол Улсын Засгийн газраас ОУИТБС-ын хэрэгжүүлэх ажлын санхүүгийн эх үүсвэрийг баталгаажуулах үүднээс нэгтгэл тайлангийн санхүүжилтийг 2010 оноос эхлэн улсын төсвөөс санхүүжүүлж байгаа бөгөөд 2012 онд 201,1 сая төгрөг, 2013 онд 183 сая төгрөг зарцуулж, 2014 онд 200 орчим сая төгрөг зарцуулахаар төлөвлөгөөтэй болно. Эдгээр төсвийн хөрөнгийг ихэнхи хэсгийг жил бүрийн нэгтгэл тайланг боловсруулахад зарцуулж байна.

Ажлын албаны санхүүжилт Дэлхийн банкны итгэлийн сангийн төслөөр хэрэгжиж байна. Санхүүжилтийн хувьд 2014 оны 5 дүгээр сард дуусч, дараагийн төслийг 9 дүгээр сард эхлүүлэхээр төлөвлөж байна.

3.5. Харилцааны мэргэжилтнийг авч ажиллуулсан нь

2011 оны 12 дугаар сарын 1-нээс харилцааны мэргэжилтэнээр ноён Санхүүгийн Батбаярыг сонгон шалгаруулан авч ажиллуулж байв. Тэрбээр хэвлэл мэдээллийн чиглэлээр мэргэшсэн, англи хэлний өндөр мэдлэгтэй ажилтан байв. Гэвч эрүүл мэндийн шалтгааны улмаас цаашид ажиллах боломжгүй болсон тул дахин сонгон шалгаруулалт зохион байгуулж хатагтай Б.Дэлгэрмаа 2013 оны 3 дугаар сарын 1-нээс ажиллаж байна.

Тэрбээр 2013 оны 5 дугаар сард Сидней хотноо Германы хамтын ажиллагааны байгууллагаас зохион байгуулсан ОУИТБС-ын харилцааны менежерүүдийн сургалтанд хамрагдсан ба өөрөө бие даан Амсдардамын их сургуульд харилцааны шинжлэх ухааны чиглэлээр 8 долоо хоногийн онлайн сургалтанд сууж сертификат авч мэдээлэл, харилцааны чиглэлээр ур чадвараа дээшлүүлж байгаа болно.

3.6. 2012 оны нэгтгэл тайлангаас гаргасан зөвлөмжүүдийг хүлээн авсан байдал

Материаллаг байдлын тодорхойлолтыг шинэлэх зөвлөмж болгосныг хүлээн авч цахим тайлагналын програм хангамжийг бий болгох хүрээнд шийдвэрлэхээр болсон.

Нэгтгэл тайланд олборлох чиглэлийн бус компаниудыг оруулахгүй байх талаар зөвлөмж гаргаж, хамрах хүрээний судалгааг хийхийг санал болгосон байна. Хамрах хүрээний судалгааг хийх зардал одоогоор хуваарилагдаагүй байгаа.

Орлогын урсгалын төрлүүдийг дахин хянаж үзэхийг санал болгосон байна. Тухайлбал, хандив тусламжийг заавал тайлагнах ангилалаас хасах гэсэн нь хандив тусламж өгч байгаа одоогийн нөхцөл байдалд нийцэхгүй тул байлгах зүйтэй гэж үзэж байна.

Төлбөрийн төрөл бүрээр зааварчилгаа өгөх нь зүйтэй гэснийг хүлээн зөвшөөрч, цахим тайлагналыг боловсруулах явцад холбогдох зааварчилгаа хийгдэх юм.

Төлбөр, хураамж, үйлчилгээний хөлсний хувьд аудитор байгууллагуудын хооронд санал зөрөлдөж байгаа нь ажиглагдаж байна. Цаг үрсэн, зарим талаар ач холбогдолгүй байж болох хураамж, үйлчилгээг 2011 оны нэгтгэл тайлангийн дагуу хасч маягтуудыг шинэчлэн мөрдөж байна.

Компаниудын тайлангийн 3 төрлийн маягтыг нэгтгэж, 1 маягт болгох нь зүйтэй гэсэн зөвлөмж өгсөн хэдий ч хэрэглээ талдаа төөрөгдүүлэх магадлалтай гэж үзэж байна.

Татвар төлөгчийн нэгдсэн дугаартай болгож өгөхийг зөвлөмж болгосныг Татварын ерөнхий газрын холбогдох албад анхааралдаа авах нь зүйтэй байна.

ОУИТБС-ын тайлангуудыг аудитын байгууллагаар баталгаажуулах асуудлыг аудиторуд байнга зөвлөмж болгодог бөгөөд энэ асуудлыг ОУИТБ-ын хуулиар зохицуулахаар төсөлд орсон байна.

Дөрөв. Ажлын төлөвлөгөөний биелэлтийн байдал, биелсэн зорилтуудын ач холбогдол;

2013 онд нийт 42 үйл ажиллагаа хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд 33 үйл ажиллагааг хэрэгжүүлж, биелэлтийн хувь 80 орчим болсон.

Хэрэгжүүлж чадаагүй гол ажил нь ОУИТБ-ын хуулийн төсөлтэй холбогдсон ажил, томоохон телевизийн нэвтрүүлэг зохион байгуулах ажил байсан. Хуулийн төслийг чанартай хийх зорилгоор хугацаагаа нарийн баримтлахгүй ажилласны үр дүнд хуулийн үзэл баримтлал, төслийг Хууль зүйн яамаар 2014 оны 3 дугаар сард батлуулсан байна.

2014 онд нийт 45 үйл ажиллагаа хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд эхний хагас жилд 25 үйл ажиллагаа хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Эдгээрээс 7 үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.

Тав. Цаашид хэрэгжүүлэх ажлын томьёолол, оролцогч талуудын оролцоог нэмэгдүүлэх тухай;

ОУИТБС-ын үйл явцын талаархи Ажлын хэсгийн дүгнэлт

5.1. Монгол Улсын ОУИТБС-ын 7 удаагийн нэгдсэн тайланг гаргаж, тайлангаас тайланд хамрагдаж байгаа компанийн тоо нэмэгдэж, аудитын нэгтгэлээр гарч байгаа зөрүү багасч байна. Монгол Улсын татвар, төлбөрийн ил тод байдлыг хангах төдийгүй ОУИТБС-ын хүрээнд хэд хэдэн асуудлыг нэмж хамруулж, тайланд тусгаад байна. ОУИТБС-ын талаар Монгол Улсад баримталж байгаа бодлого, хэрэгжүүлж байгаа ажил, үр дүнг тайланд дэлгэрэнгүй тусгасан болно. Онцлон

тэмдэглэхэд ОУИТБС-ыг хэрэгжүүлж байгаа стратеги, ажлын төлөвлөгөө уян хатан, оролцогч талуудын оролцоог хангасан байдлаар хэрэгжиж байгаа нь дээрх ололт амжилтын гол тулгуур болж байна.

5.2. ОУИТБС-ыг хэрэгжүүлэхэд оролцогч талууд Засгийн газар, компаний, иргэний нийгмийн байгууллагуудын оролцоо, санаачлага сайн байгаа.

5.3. Монгол Улсад ОУИТБС тогтвортой хэрэгжиж байгаа ч хөрөнгө санхүүгийн хязгаарлагдмал байдал, хууль эрх зүйн тодорхойгүй байдлаас улбаалан томоохон шинэчлэл, өөрчлөлтийг хийх бололцоо дутмаг байгааг хүлээн зөвшөөрч байна. Хууль эрх зүйн байдал тодорхойгүйгээс гарган зөрүүг шийдвэрлэхэд хүндрэл үүсгэж байна.

5.4. Монгол Улсын ОУИТБС-ын нэгдсэн тайлан он дамжин гарч байсныг зогсоож дараа онд нь багтаан гаргах болсон их чухал юм.

5.5. Мөн сургалт сурталчилгааны чиглэлээр ихээхэн хүчин чармайлт, цаг хөрөнгө гаргах нь зайлшгүй болжээ. Тухайлбал, иргэний нийгмийн байгууллагын төлөөллийг сургалтад хамруулах, компанийн санхүүгийн ажигнуудад зориулсан сургалтын чанарыг сайжруулах, тайланг ойлгомжтой хэлбэрээр орон нутгийн иргэдэд хүргэж сурталчлах, энэ чиглэлээр оновчтой бүтэц, зохион байгуулалт бий болгож чадаагүй байна.

Зургаа. Тайланг боловсруулсан, баталсан огноо 2014 оны 6 дугаар сарын 16-ны өдөр